



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 03 өдөр


Дугаар 67

Номгон

Ээлжит хуралдааны тов зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит YI хуралдааныг 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 10 цагт Баянхонгор сумын төвд зарлан хуралдуулж дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.
 - 1.1. Аймгийн 2017 оны төсөвт тодотгол хийх тухай
 - 1.2. "Хонгорын хүдэр" ХХК-ний үйл ажиллагааны тухай
 - 1.3. Орон нутгийн өмчөөс 2017 онд хувьчлах хөрөнгийн жагсаалт батлах тухай
2. Хуралдааны бэлтгэлийг сайтар хангаж, асуудлыг Тэргүүлэгчдээр урьдчилан хэлэлцүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.



011-015